

**НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН 2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 04 -НИЙ ӨДРИЙН ШУУРХАЙ  
ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН  
ЗАХИРАГЧААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР**

2023 оны 12 дугаар сарын 04

Улаанбаатар хот

№	Үүрэг даалгаврын дагуу хийж хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Үүрэг, даалгавар биелүүлээгүй шалтгаан	Цаашид авч хэрэгжүүлэх арга зам	Оноо
<b>Үүрэг даалгавар НЭГ:</b> Хот, нийтийн аж ахуйн чиглэлээр дүүргүүдэд гэрээ байгуулан ажиллаж байгаа аж, ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг үргэлжлүүлэн, үр дүнг дүгнэн ажиллахад онцгой анхаарах				
1	Хот, нийтийн аж ахуйн чиглэлээр дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй хог тээвэрлэгч байгууллага Чингэлтэй дүүргийн Тохижилт үйлчилгээ ХХК, “Найши трейд” ХХК, гэрэлтүүлгийн ашиглалт хамгаалалт хариуцсан “Соён дрийм” ХХК-тай гэрээ байгуулан ажиллаж байна. 2023 онд хийж хэрэгжүүлсэн ажлыг дүгнэх ажил 12 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.			90
<b>Үүрэг даалгавар ХОЁР:</b> 2024 оны 03 дугаар сараас нийслэлийн нутаг дэвсгэрт явган хүний замын тохижилтын ажлыг эхлүүлэх (эх орны үйлдвэрийн чулуу, бродюр ашиглах)				
2	2024 оны дүүргийн төсөв батлагдсаны дараагаар зураг төсвийн ажлыг эхлүүлэн 3 дугаар сард ажлыг эхлүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Материалын хийц, явган замын хавтанг дотоодын үйлдвэрлэлийн чулуу, хөтөч хавтан ашиглан хийж гүйцэтгэхээр төлөвлөн ажиллаж байна.			90
<b>Үүрэг даалгавар ГУРАВ:</b> Төсөв батлагдсаны дараа худалдан авалтын эрхийг дүүрэгт шилжүүлсэн захирамж гаргах, худалдан авалтын тендерийг энэ сардаа зарлаж дуусгах				
3	Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар “Дүүргийн 2024 оны төсөв батлах тухай” тогтоол батлагдсаны дараа Төсвийн ерөнхийлөн захирагчаар 2024 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлуулан Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар болон Сангийн ямаар системд батлуулж ажиллана. Дүүргийн Засаг даргын захирамжаар үнэлгээний хороо байгуулан, захиалагч байгууллагаас зураг төсөв, ажлын даалгавар ирсэн өдөрт багтаан төсөл арга хэмжээнүүдийн худалдан авах ажиллагааг <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> болон <a href="http://www.chingeltei.gov.mn">www.chingeltei.gov.mn</a> цахим системээр дамжуулан ил тод нээлттэй зарлаж, урилга, үр дүнг нийтлэн шуурхай ажиллана.			90
<b>Үүрэг даалгавар ДӨРӨВ:</b> Худалдан авалттай холбоотой ажлын тендер зарлах, сонгон шалгаруулах, худалдан авалтын гэрээ хийх зэрэг ажлууд 2024 оны 03 сард бүрэн дууссан байх,				
4	2024 онд хэрэгжих төсөл арга хэмжээний тендерийг 2024 оны 1 дүгээр улиралдаа багтаан зарлан, сонгон шалгаруулалтыг хийж, гэрээ байгуулах эрх олгон ажиллана. 2024 оны 01			90

	дүгээр сарын 01-ний өдрөөс Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулга, холбогдох журам мөрдөгдөж эхлэхтэй холбогдуулан тендерийн баримт бичийг боловсруулах бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. 2024 онд хэрэгжих хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг дүүргийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан үнэлгээний хороо нь захиалагч байгууллагаас зураг төсөв, ажлын даалгавар ирсэн өдөрт багтаан төсөл арга хэмжээнүүдийн худалдан авах ажиллагааг <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> болон <a href="http://www.chingeltei.gov.mn">www.chingeltei.gov.mn</a> цахим системээр дамжуулан ил тод нээлттэй зарлаж, урилга, үр дүнг нийтлэн шуурхай ажиллана.			
<b>Үүрэг даалгавар ТАВ:</b> Шинэ оноо угтахтай холбогдуулан хотын төвийн гудамжны чимэглэл, гэрэлтүүлэгт анхаарч аж, ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллах, Сүхбаатарын талбайд сүлд мод засах ажлыг чанартай зохион байгуулах				
5	“Шинэ жилийн худалдаа” арга хэмжээг дүүргийн 5 дугаар хороо Тусгаар тогтнолын талбайд 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн зохион байгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Арга хэмжээний хүрээнд сүлд мод, талбайн гэрлэн чимэглэлийг “Соён дрийм” ХХК-тай гэрээ байгуулан ажиллаж байна. Дүүргийн Анкарагийн гудамж, Самбуугийн гудамжинд хүнс, худалдаа үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа нийт 28 иргэн, аж ахуйн нэгжид 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор гэрэлтүүлэг бүхий тохижилт хийж, ая тухтай орчныг бүрдүүлэх талаар чиглэл хүргүүлсэн.			90
<b>Үүрэг даалгавар ЗУРГАА:</b> Дүүргийн нутаг дэвсгэрт хөл хөдөлгөөн ихтэй төвлөрсөн талбайд шинэ жилийн худалдааг (СИпз1таз тагке!) зохион байгуулах хөрөнгийн эх үүсвэрийг гаргаж, нэг стандартын дагуу арга хэмжээг зохион байгуулах				
6	“Шинэ жилийн худалдаа” зохион байгуулах ажлын хүрээнд дүүргийн 5 дугаар хороо Тусгаар тогтнолын талбайд түргэн хоолны чиглэлээр 6, худалдаа үйлчилгээний 4 нийт 10 иргэн, аж ахуйн нэгжийг нэг стандартын дагуу худалдаа, үйлчилгээний арга хэмжээг зохион байгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.			90
<b>Үүрэг даалгавар ДОЛОО:</b> Хүн ам олноор суурьшсан хороолол, хотхоны орц гарц гаргах зэрэг нэн яаралтай шийдвэрлэх асуудлын судалгааг гаргаж, санал танилцуулах				
7	Тус дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд орон сууц, хотхоны орц гарц хаасан 90 байршлын судалгааг нэгтгэж гаргасан байна. Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн хүрээнд зам талбайн орц, гарцыг хааж, зөвшөөрөлгүй байршуулсан 7 ширхэг автомат хаалтыг албадан буулгаж, нийтийн эзэмшлийн зам талбайг чөлөөлсөн.			70

ТАНИЛЦСАН:  
ЗАСАГ ДАРГА

Н.БАТСҮМБЭРЭЛ

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН ДАРГА

П.БАЯНБААТАР

ХЯНАСАН:  
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Л.БАЯРМАА

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ  
ХЭЛТСИЙН ДАРГА

Н. НАРАНЗУЛ

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ  
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН  
НЭГТГЭСЭН:

Э.ХУЛАН

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН  
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Т.ТҮВШИНЖАРГАЛ